



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/309

Булган сум

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд сургалт зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд “Ажлын байранд нийгэм-сэтгэл зүйн эрүүл орчныг бүрдүүлцгээе!” уриан дор “Стресс бухимдлаа ухаалгаар удирдах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулахад 600,000 (зургаан зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Сургалтад төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтныг бүрэн хамруулж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Насанжаргал), сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т тус тус даалгасугай.

3.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326910427